



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 03

Турт

2017 оны төсвийн тодотгол
батлах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1.2-ын “б”, Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-н 2017 оны 4 дүгээр сарын 13 өдрийн тогтоол, “Төсвийн тухай хуулийн “6 дугаар зүйлийн 6.4.8, 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.2, 60 дүгээр зүйлийн 60.2.4, 64 дүгээр зүйлийн 64.1.2 заалтуудыг, Хөвсгөл аймгийн ИТХ-н ээлжит 4 дүгээр хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн Хөвсгөл аймгийн Ханх сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит 2 дугаар хурлаас ТОГТООХ нь:

1. Ханх сумын 2017 оны орон нутгийн орлогын төлөвлөгөөний өөрчлөлтийг тодотголыг 1 дүгээр хавсралтаар, Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн өөрчлөлтийг 2 дугаар хавсралтаар, орон нутгийн байгууллага болон санхүүгийн дэмжлэгийн өөрчлөлтийг 3 дугаар хавсралтаар, тусгай шилжүүлэгийн байгууллагын төсөвт болон сум хөгжүүлэх сангийн эхний үлдэгдэл зарцуулах эрхийг 4 дүгээр хавсралтаар, төсвийн эрх захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр хүрэх үр дүнгийн тоон болон хэмжээний үзүүлэлтийг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагуудын 2017 оны төсөвт тодотголыг тусгаж, сарын хуваарьт өөрчлөлт оруулан мөрдөж, ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллахын Сумын засаг дарга /Б.Эрдэнэбаатар/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга /Л.Дуламхүү /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ДУЛАМХҮҮ